

БАТЛАВ
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА **Ж.АЛТАНГЭРЭЛ**

2020 оны дугаар сарын

**“НАЛАЙХ ДҮҮРГИЙН 1 ДҮГЭЭР ХОРООНЫ ЭНГЭР ШАНДЫН ХЭСЭГТ АВТОБУСНЫ
БУУДАЛ БАРЬЖ БАЙГУУЛАХ, АВТОЗАМЫН ГАРЦ, ГАРАМЫН ТЭМДЭГ,
ТЭМДЭГЛЭГЭЭ, ХУРД СААРУУЛАГЧ ХИЙХ” ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: “Налайх дүүргийн 1 дүгээр хорооны Энгэр шандын хэсэгт Автобусны буудал барьж байгуулах, автозамын гарц, гарамын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч хийх”

Тендерийн дугаар: **НДХААА/202008036**

Налайх дүүрэг
2020 он

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр

Налайх дүүргийн Худалдан авах ажиллагааны алба нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Налайх дүүргийн 1 дүгээр хорооны Энгэр шандын хэсэгт Автобусны буудал барьж байгуулах, автозамын гарц, гарамын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч хийх”**

НДХААА/202008036 дугаартай тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендер хүлээн авах этгээд: Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (**www.tender.gov.mn**) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгийг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр илгээнэ.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж **50.000** (тавин мянга) төгрөгийг **www.tender.gov.mn**-ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Үнийн саналыг **2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 00 минут**-аас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (**www.tender.gov.mn**)-ээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 10 цаг 30 минут**-д нээнэ.

Дотоодын давуу эрх: **Тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон холбогдох бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж,
Худалдан авах ажиллагааны алба, 2 давхар,
Холбоо барих утас: 70233788**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн

- саналын хүчинтэй байх хугацаа** хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (a) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь эрх бүхий болон гэрээ хэрэгжүүлэх чадварыг нотлоход дараах материалыг ирүүлэх шаардлагатай. Үүнд:</p> <p>1.Улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.</p> <p>2.Тендерт оролцогч тухайн ажлыг гүйцэтгэхэд дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Барилга хот байгуулалтын яамнаас олгодог: БУ.2.1.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохижилт (хуучнаар) БА-8.1. Барилга байгууламжийн засвар, засал чимэглэл, интерьер, орчны тохижилтын ажил болон түүнээс дээш</p> <p>3.Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Тендерт оролцогч татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй ба www.tender.gov.mn цахим системээс нээлт болсон өдрөөр татварын тодорхойлолтыг татан авч үзнэ.</p> <p>4.Харьяа дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс нийгмийн даатгалын шимтгэлийн өргүй тухай тодорхойлолт.</p> <p>5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ.</p> <p>6. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл: “Шаардлагатай” - Шүүхийн төрөлжсөн архив, Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс тус тус тодорхойлолт ирүүлнэ.</p> <p>7.Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн өргүй тухай банкны тодорхойлолтыг улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэлтэй болон харилцагч банк тус бүрээс ирүүлнэ.</p> <p>Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Цаг: 10 цаг 00 минут</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Налайх дүүрэг, 2 дугаар хороо, Хуульчдын гудамж, Худалдан авах ажиллагааны алба. Давхар болон өрөөний дугаар: 2 дугаар давхар, Нээлтийн өрөө Огноо: 2020 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 2.3	<p>Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах</p>

үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ

ТӨӨЗ 3.1

1.Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны хуваарийг баталгаажуулан ирүүлнэ /Ажил гүйцэтгэх хугацаа 30 хоног./

2.Ажлын талбайтай танилцсан тухай тэмдэглэл, фото зургийн хамт баталгаажуулан ирүүлнэ.

3.Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны санхүүгийн тайланг цахим системээр дамжуулан Сангийн яамны мэдээллийн сангаас тендерт оролцогчдын борлуулалтын орлого болон шаардлагатай мэдээллийг (эсхүл холбогдох байгууллагаас бичгээр ирүүлсэн) үндэслэл болгоно.**

4.Дараах хүснэгтэд үзүүлсэн голлох болон инженер техникийн ажилтныг ажиллуулна.

№	Албан тушаал	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан туршлага	Мэргэжил
1	Барилгын инженер	1	3 болон түүнээс дээш жил	Барилгын инженер
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	1	1 болон түүнээс дээш жил	ХАБЭА сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх
3	Автозамын талбайн инженер	1	3 болон түүнээс дээш жил	Автозамын инженер

- Инженер техникийн ажилчдын жагсаалтыг ирүүлнэ.
- Дээрх инженер техникийн ажилтнуудын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар, иргэний үнэмлэхний хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн ирүүлнэ.
- Барилгын инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь тухайн байгууллагын үндсэн ажилтан байх ба ажилтны ажлын туршлагыг баталгаажуулахын тулд нийгмийн даатгалын дэвтрийн даатгуулагчийн ажил, албан тушаалын өөрчлөлтийн тэмдэглэл, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажуулна. Автозамын талбайн инженер нь гэрээт ажилтан байж болно.

5. Ашигтай ажилласан жил: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд ашигтай ажилласан байна.**

6. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй өртөгтэй ажил гүйцэтгэсэн ажлыг нотлох баримт буюу Ажил гүйцэтгэх гэрээ, Улсын комиссын актын хуулбарыг хавсаргана. Ижил төстэй ажилд барилгын гадна тохижилтын ажлын туршлагыг ойлгоно.**

7.Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн машин механизмууд:

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Тоо	Хүчин чадал

1	Ачааны машин	1	
2	Автокран	1	
3	Зуурмаг зуурагч машин	1	
	Индүү	1	

- Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын бөглөж ирүүлнэ.
- Байгууллагын өөрийн эзэмшлийн машин механизм, багаж хэрэгсэл нь тухайн байгууллагын нэр дээр байх ба гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.
- Түрээсээр ашиглах бол гэрчилгээний хуулбарыг нотариатаар гэрчлүүлэн, түрээсийн гэрээг эх хувиар хавсаргана.
- Хуулбар нь тод гаргацтай байна.

8.Борлуулалтын орлого: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэг жилд борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.**

9.Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл [А] болон [Б] дахь заалтын нийлбэрээр тус тус тодорхойлно. Үүнд:

А.Байгууллагын дансны үлдэгдэл /Харилцагч банкны/

Б. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт /Банкны судлан үзэж нөхцөл шаардлага хангасан тохиолдолд зээл олгох боломжтой гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/. Зээл авах баталгаажсан тодорхойлолт байна.

10.Төсвийг зураг, ажлын тоо хэмжээний дагуу тооцож эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулан ирүүлнэ.

- ЗТБХБ-ын сайдын 2012 оны 01 сарын 13-ны өдрийн 181 дүгээр тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрэм,
- БХБ-ын сайдын 2012 оны 185 дугаар тушаалаар шинэчлэн баталсан барилгын норм ба дүрмийн дагуу тооцно.
- Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсөв зохиох програмаар гүйцэтгэнэ.

11.Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг ирүүлнэ.

12.Шалгарсан тохиолдолд гэрээний үнийн дүн, ажил гүйцэтгэх үе шатны хуваарьт багтаан ажлыг чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай баталгааг албан бичгээр ирүүлнэ.

13.Татвар, нийгмийн даатгал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон холбогдох эрх бүхий байгууллагуудаас тодруулга авахад татгалзах зүйлгүй тухай албан бичиг ирүүлнэ.

14.Тендерт оролцогчийн ирүүлсэн санал нь техникийн тодорхойлолтоос зөрсөн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

ТӨӨЗ 4.1 Тендерийн үнэ: Тендерийн үнэд зураг төсөв гүйцэтгэгчид олгох 200.000 /хоёр зуун мянга/ төгрөгийг тооцож ирүүлнэ.

ТӨӨЗ 5.1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ



АЖЛЫН ДААЛГАВАР

Байршил: Налайх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр Энгэршандын хэсэгт байрлах "Налайхаас-Городок", "Городокоос-Налайх" чиглэлийн автобусны зогсоол /Цэргийн ангийн автозам дагуу/

1. Хийх ажил: 2 ширхэг автобусны буудлын сүүдрэвч худалдан авч байрлуулах, суурилуулах, чиглэлийн тээврийн хэрэгслийн тэмдэг, тэмдэглэгээ, явган хүний гарцын шугам, хурд сааруулагч байрлуулах ажлыг хийнэ. Нэг автобусны буудлын сүүдрэвчинд шаардагдах төсвийг гаргасан.

Анхаарах зүйл: /2 автобусны буудал нэг ижил стандарт, хэмжээгээр хийгдэнэ/.

№	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо
1	Сандал	ш	2
2	Бетондах талбай h-0.1м	М3	2
3	Саравч	ш	2
4	Саравчинд орох труба	м	40
5	Саравчинд орох лист 0.3 мм	м2	20
6	Саравчинд орох шил, циллойд 10 мм	м2	9,6
7	Гэрэлтүүлэг	м	2,4
8	Гэрэл дотор монтажтай	м	1,8
9	Хогийн сав	ш	2
10	Тэмдэг, тэмдэглэгээ	ш	10
11	Хурд сааруулагч 7м*1,5м	М2	10,5
12	Явган хүний гарцын шугам 50см*3м	М2	10,5

Архитектур төлөвлөлт:

Автобусны буудлыг төлөвлөхдөө хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон одоо байгаа зам талбайтай уялдуулан хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх мөн давхар ашиглагдаж болохоор зар сурталчилгааны самбартай байхаар хийнэ. Энэхүү зогсоол нь 1.2 х 3.0 м хэмжээтэй 2.4 м өндөртэй байна.

Сүүдрэвчийн хажуугийн хэсэг нь шөнийн цагт гэрэлтдэг, гэрлийн монтаж нь далд хэлбэртэй, мэдээлэл тавихад дотроос нь хоёр талаас гэрэлтдэг байдалтай байна. Сүүдрэвчийн хажуугийн хэсгийн гэрэлтүүлэгийн самбарт тавьсан мэдээллийг тухай бүр өөрчлөх боломжтой, шил циллойд хагалж, гэмтээхгүйгээр реклам, сурталчилгааны материалыг солих боломжтой байдлаар хийнэ.

Хийц бүтээц:

Буудлын саравчны суурь гэрэлтүүлгийн самбарыг байрлуулахдаа нүх ухаж, М200 маркын бетон цутгаж арматурлан анкер гарган бэлдэж, уг анкарт баганыг бэхлэж бооно.

Талбайг тэгшилж нягтаршуулж бетон зуурмагаар цутгаж шалыг бэлтгэнэ.


Тоног төхөөрөмж: Төлөвлөж буй сандал, төмөр саравч, хогийн сав зэрэг нь стандарт хангасан байна. Хогийн сав нь өвөл хөлдөхгүй, цэвэрлэхэд хялбар, зэвэрдэгүй төмөр материалаар хийгдсэн байна. Сандал нь өвөл хөлдөхгүй хагарч бутарахгүй, цагаан өнгийн төмөр материалаар хийнэ.

2.Чиглэлийн тээврийн хэрэгслийн дараах тэмдэг, тэмдэглэгээг хийнэ.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 5.18. Хурд сааруулагчийн тэмдэг-2, 5.19а, б. Явган хүний гарцын тэмдэг-2, 5.21. Чиглэлийн тээврийн хэрэгслийн буудлын тэмдэг-2 ширхэг, Явган хүний гарцын болон хурд сааруулагчийн анхааруулах тэмдэг-2, 2 хэрэглэгдэнэ.

Жич. Замын тэмдэг, тэмдэглэгээ, хаалтыг стандартын дагуу хийж, дүүргийн Замын Цагдаагийн тасгаас мэргэжлийн зөвлөгөө авч хамтарч ажиллана.

Автобусны буудлын 2 сүүдрэвчийг байрлуулсаны дараа арчлалт, хамгаалалтыг 3 сарын хугацаанд хариуцаж, Захиалагч талд актаар хүлээлгэж өгнө.

ХЯНАСАН:
ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  Ц.ТУНГАЛАГ

2020 оны . . . сарын өдөр

БОЛОВСРУУЛСАН:
ХҮҮХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН  М.ТӨГСӨӨ

Шаардлагатай зардлын тооцооны задаргаа:

№	Нэр	Материалын зардал		Нийт зардал Нийт үнэ	Тайлбар
		тоо	Нэг бүрийн үнэ		
1	Саравч угсралтын ажил /хогийн сав, сандалтай/	2	7,381,644	14,763,288	Дан төмрөөр хийгдэнэ. Хажуугийн рекламны самбар циллойдон шилтэй гэрэлтдэг байна.
2	Тэмдэг тэмдэглэгээ	10	160,000	1,600,000	Нэг буудалд 5 тэмдэг, тэмдэглэгээ
3	Явган хүний гарцын шугам	1	450,000	450,000	2 саравчны голоор 1 шугам хийгдэнэ
4	Хурд сааруулагч 7м*1,5м	0,5*2	372,612	372,612	Нэг талдаа хагас хурд сааруулагч 2 саравчны захад байрлана
НИЙТ				17,185,900	

Тэмдэг, тэмдэглэгээ: явган хүний гарцын анхааруулах тэмдэг-2, явган хүний гарцын тэмдэг-2, хурд сааруулагчийн анхааруулах тэмдэг-2, хурд сааруулагчийн тэмдэг-2, автобусны буудлын тэмдэг-2 нийт 10 тэмдэг тэмдэглэгээ байна.

Тав. ЗУРАГ

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх**
 2. **Төслийн менежерийн шийдвэр**
 3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх**
 4. **Аюулгүй байдал**
 5. **Зааварчилгаа**
 6. **Маргааныг шийдвэрлэх**
 7. **Ажлын хөтөлбөр**
 8. **Зөрчил, гологдол илрүүлэх**
 9. **Зөрчил, гологдол арилгах**
 10. **Зөрчил,**
- 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
 - 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
 - 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
 - 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
 - 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
 - 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
 - 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
- 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
 - 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
 - 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
 - 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
 - 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
 - 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

**гологдол
арилгахгүй
байх**

заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1	<p style="text-align: center;">Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Налайх дүүргийн 1 дүгээр хорооны Энгэр шандын хэсэгт Автобусны буудал барьж байгуулах, автозамын гарц, гарамын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч хийх” <i>НДХААА/202008036</i></p>
ГЕН 2.1	<p>Ажил нь “Налайх дүүргийн 1 дүгээр хорооны Энгэр шандын хэсэгт Автобусны буудал барьж байгуулах, автозамын гарц, гарамын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч хийх”ээс бүрдэнэ. Ажлын талбай нь <i>Налайх дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр Энгэр шандын хэсэг,</i></p>
ГЕН 3.1	<p>Төслийн менежер нь <i>Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Ж.Алтангэрэл</i></p>
ГЕН 4.1	<p>Ажил эхлэх өдөр <i>Гэрээ байгуулснаас өдрөөс хэрэгжинэ</i></p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>2020 оны 10 дугаар сарын 20</i></p>
ГЕН 7.1	<p>Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.</p>
ГЕН 9.1	<p>Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.</p>
ГЕН 13.1	<p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5 хувь байна.</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 50 хувь байна.</p>
ГЕН 17.1	<p>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 3 хоногийн дотор гаргаж өгнө</p>

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

_____ (Тамга, тэмдэг)

_____ (Гарын үсэг)

_____ (Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;

- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]